



## ГААЛИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл боловсруулах дараах үндэслэл, шаардлага байна.

### 1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Засгийн газраас хүн амын өвчлөл нас баралтын тэргүүлэх шалтгааны нэг болж байгаа гепатитын вирусийн халдвараас сэргийлэх, уг халдвартыг оношлох, эмчлэхэд анхаарал хандуулж олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Тухайлбал, 2011-2015 онд Халдварт өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр, Вируст гепатиттай тэмцэх сэргийлэх зорилтот хөтөлбөр, 2017-2021 онд “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд “Элэг бүтэн Монгол” арга хэмжээг хэрэгжүүлэн гепатитын D вирусийн халдвартай иргэдийг эмчилгээнд хамруулахаар тусгасан.

### 1.2.Практик шаардлага

Монгол Улс гепатит вирусийн халдвартын тархалт өндөртэй орны тоонд ордог бөгөөд энэхүү халдвараас үүдэлтэй элэгний хатуурал, хорт хавдар нь хүн амын өвчлөл нас баралтын тэргүүлэх шалтгаан болж байна. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-аас хийсэн тооцооллоор манай улсад гепатитын D вирусийн халдвартай 60 гаруй мянган иргэн байх магадлалтай байна.

Эмийн чанар, аюулгүй байдлын хатуу зохицуулалттай хяналтын байгууллага болох Европын эмийн агентлагаас Булевиртид эмийг эмийн бүртгэлд албан ёсоор бүртгэж, гепатитын B, D вирусийн архаг халдвартын эмчилгээнд хэрэглэх зөвшөөрөл олгосон. Үүнтэй уялдуулан манай улс гепатитын B, D вирусийн эмчилгээний заавраа шинэчлэн баталж 2024 оноос мөрдөж эхлээд байна.

Булевиртид эм нь 47 амин хүчлээс тогтсон нийлэг эм бөгөөд элэгний эсэд D вирус нэвтрэхийг saatuuлах үйлчилгээтэй болно.

**Гепатитын В, D вирусийн эмчилгээнд хэрэглэх Булевиртид эмийн үнэ өндөр байгаатай холбоотойгоор тус эмчилгээ шаардлагатай иргэд эмчилгээнд хамрагдаж чадахгүй байна.**

**Эрүүл мэндийн яамнаас Булевиртид эмийн албан ёсны патентыг эзэмшигч АНУ-ын "Gilead Sciences Inc" компанийтай эмийн үнийг хэд дахин бууруулах талаар яриа хэлэлцээг үргэлжлүүлэн хийж байна.**

**Эрүүл мэндийн тухай хуулийн 4.1.2-д "хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг ялгаварлан гадуурхахгүйгээр тэгш, хүртээмжтэй үзүүлэх" гэж заасны дагуу гепатитын В ба D вирусийн хавсарсан халдвартай иргэдэд шаардлагатай эмийн үнийг бууруулж иргэдэд учрах санхүүгийн дарамтыг багасгах зорилгоор Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлага бий болж байна.**

#### **Хоёр.Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

**Хуулийн төслийг гурван зүйлтэй байхаар боловсруулна. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлээр Гепатитын D вирусийн эмчилгээнд хэрэглэх зорилгоор импортлох Булевиртид эмийг гаалийн албан татвараас чөлөөлөх талаар, 2 дугаар зүйлээр гаалийн албан татвараас чөлөөлөгдхөн эмийн жагсаалтыг Засгийн газар батлахаар, 3 дугаар зүйлээр хуулийг дагаж мөрдөх хугацааг тус тус зохицуулахаар тусгана.**

#### **Гурав.Хуулийн төсөл батлагдсанаар үүсэх нийгэм, эдийн засгийн үр дагавар, гарах үр дүн**

**Хуулийн төсөл батлагдсанаар дараах зерэг үр дүн гарна. Гепатитын D вирусийн халдвартай иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж сайжирч, хүн амын өвчлөл, нас бааралтын тэргүүлэх шалтгаанд багтаж байгаа элэгний хатуурал, элэгний хорт хавдрын шалтгаант нас бааралт буурна. Үүний зэрэгцээ иргэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авахад учрах санхүүгийн дарамт буурна.**

#### **Дөрөв.Хууль гарсантай холбогдуулан шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хууль тогтоомжийн талаар**

**Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжтой нийцэж байгаа бөгөөд төсөл батлагдсантай холбогдуулан шинээр боловсруулах болон нэмэлт, өөрчлөлт орох шаардлагатай хууль тогтоомжууд байхгүй болно.**

-----оОо-----